

FUNDERMAX КОМПАКТ ТАВЦАН ТЕХНИКИЙН ЗААВАРЧИЛГАА

Хэрэглээ, боловсруулалт, суурилуулалт, арчилгаа

1

ХЭРЭГЛЭЭ

- 8мм, 12 мм зузаантай компакт хавтанг тавцан болон, гал тогооны ар хамгаалалтын хананд хэрэглэж болно.

- Индукцын плиткатай бол плиткаг ар хананаас 5см зайтай суурилуулна. Газын плиткатай бол 20см зайтай суурилуулах шаардлагатай. Уг материал нь Гал дэмжихгүй үзүүлэлттэй (Галд авалцахад улам тархаахгүй) бөгөөд Галд шатдаггүй материал биш болно.

- Доороо тулгуургүй хэт урт текэнд тохиромжгүй бөгөөд 80см бүрд даац авах тулгууртай текэн дээр хэрэглэнэ.

- Текийг илүү гаргаж хийх үед илүү гарах хэсэг нь 20 см-с ихгүй байх шаардлагатай.

- Дугуйруулж, хэлбэртэй зүсвэртэй тавцан, ширээ хийхэд тохиромжтой.

- Зориулалтын дагуу гал тогооний тавцан, тек, ширээний тавцан, угаалгын өрөөний тавцан, гал тогооны ар плитаны оронд “ар хамгаалалтын хана” хийхэд зориулагдсан хавтан бөгөөд өөр зориулалтаар ашиглахад тохиромжгүй.



Газын плитка

(хананаас 20см зайнд)




Индукцын плитка

(хананаас 5см зайнд)



Плиткаг ханатай ойрхон суурилуулсан тохиолдолд ямар ч материал галын нөлөөнд өртөнө. Тиймээс плитка ханын стандарт зайг баримтлахыг зөвлөж байна.


Уг стандарт зайг авах боломжгүй тохиолдолд:



Плиткаг ханатай нэгэнт ойр суулгасан бол дараах арга хэмжээнүүдийг авах боломжтой: Tempered Glass (галд тэсвэртэй шил) плитканы ард хийх эсвэл метал sheet хийж ар хавтангаа хамгаалахаас гадна галын аюулгүй байдлыг хангана.

БОЛОВСРУУЛАЛТ


-Компакт хавтанг заавал хэвтээ байрлалд тэгш гадаргуу дээр хадгална.



-Хавтанг зүсвэрт оруулахаас өмнө, хэвийн тасалгааны температуртай газар 24 цаг байлгасны дараа зүсвэрт оруулна. Орчны чийгшил 40-60%-с ихгүй байх.

1mm

ил харагдах гар хүрэх бүх хэсгүүдийг фаскдах шаардлагатай (1мм-ээр фаскдахыг зөвлөж байна.)



-Бид зүсвэрийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд та манай зүсвэрийн үйлчилгээг сонгон хавтангаа зүсүүлэхийг бид зөвлөж байна.

-CNC машинаар зүсэхийг зөвлөдөг энэ нь тавцан илүү цэвэрхэн мөн хэлбэртэй зүсэх, ховил гаргах зэрэгт тохиромжтой байдаг. Хөрөөгөөр зүсэх бол хөрөө ир сайтай байх, мөн бага хурдаар зүсэх шаардлагатай. (Компакт материал нь маш хатуу тул их хурдаар зүсвэл хөрөөний ирийг мохоох, хугалах, хэт халалт үүссэнээр хавтангийн ирмэг түлэгдэх эрсдэлтэй.)

-Нүдэнд ил харагдах гар хүрэх бүх ил хэсгүүдийг фаскдах шаардлагатай (1мм-ээр фаскдахыг зөвлөж байна.) CNC болон фрезерээр фаскдах боломжгүй болсон тохиолдолд 1000-тай зүлгүүрээр заавал ирмэгийн хурц өнцгийг зүлгэж зөөлрүүлнэ! Энэ нь хавтан эмтрэхгүй байх болон хурц ирмэгт гараа зүсэхээс сэргийлнэ.

-Тавцанг суурилуулах хажуугийн хана, кабинетаас нэг талдаа 2-5мм зайтай байхаар тооцож зүснэ. Дараа нь энэ зайг суурилуулалтын үед силикондож битүүмжилнэ.

FUNDERMAX КОМПАКТ ТАВЦАН ТЕХНИКИЙН ЗААВАРЧИЛГАА

Хэрэглээ, боловсруулалт, суурилуулалт, арчилгаа

2

СУУРИЛУУЛАЛТ


-Компакт хавтанг заавал хавтангийн 2 талаас агаар орж байх боломжтой байдлаар суурилуулна. Гал тогооны шүүгээн дээр тавцанг суурилуулахдаа шүүгээний дээд хэсэг нь онгорхой, тэгш шүүгээн дээр суулгана. **(Зураг 1)**

-Гал тогооны шүүгээнүүд бүгд тэгш байх шаардлагатай- шүүгээнүүд дээр доор байж болохгүй, тэгш ус хэрэглэн бүх шүүгээг тэгшлэж байж суулгана.


-Ар хамгаалалтын компакт хавтанг суулгахдаа шууд ханан дээр суурилуулахгүй, дай мод/хавтан/профил г.м дайг хананд тогтоосны дараа дай дээр хавтангаа тогтооно. Ингэснээр хавтангийн араар агаар чөлөөтэй сэлгэдэг. **(Зураг 2)**

-Плитканы нүх, угаалтуурын нүх зэрэг нүх гаргахдаа заавал буланг багадаа 5мм-ийн радиустайгаар дугуйруулж зүснэ. Хурц өнцөг гаргаж орхиж болохгүй.




-Булан эргэсэн L хэлбэрийн гал тогоонд тавцанг залгахдаа зориулалтын компакт холбогч ашиглахыг зөвлөж байна. **(Зураг 3), (Зураг4)**



Компакт тавцан болон хавтанг суулгахдаа агаар солилцох зайгүй суулгаснаас хавтангийн хэлбэрт гажилт үүсч болзошгүй байдаг тул заавал агаарын зайтай суулгахыг анхаарна уу.



(Зураг 3)



(Зураг 4)

АРЧИЛГАА

-Компакт хавтан нь толбонд харьцангуй тэсвэртэй боловч өөр ямар ч төрлийн гадаргуутай адил тавцан дээр цай, вино, тос зэрэг толбо их үлдээдэг бодисыг удаахгүй арчиж авах нь чухал ба ингэснээр цэвэрлэгээг хялбарчилна. Аливаа толбыг арилгахдаа метал материалтай үрэгчээр үрэлгүй зориулалтын цэвэрлэгч бодисыг гадаргуу дээр цацаж/түрхэн хэсэг хугацаанд байлгасны дараа арчина.

-Компактын ирмэг нь зүсвэрээс гарсаны дараа зүсвэрийн үлдэгдэлд сааралтсан байдаг тул ялангуяа хар өнгийн голтой хавтангийн голны тоосыг сайн арчиж аваад энгийн тос (ургамлын тос байж болно) нэг удаа өнгөлөхөд өнгө нь тодордог.

